



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/231

Мандсговь

Г "Архидалтгүй аймаг – Дундговь" 7
дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2018-2020 онд хэрэгжүүлэх эрүүл зан үйлийг дэмжсэн "Архидалтгүй аймаг - Дундговь" дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоотой төлөвлөн, зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Түвшинбаяр), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа) болон сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсвийг жил бүр Орон нутгийн хөгжлийн сангийн хөтөлбөр арга хэмжээний зардалд тусган санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (А.Ганбат), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0200743

Аймгийн Засаг даргын 2018
оны 05 дугаар сарын 28 -ны
өдрийн 103 дугаар захирамжийн
1 дугаар хавсралт

ЭРҮҮЛ ЗАН ҮЙЛИЙГ ДЭМЖСЭН
"АРХИДАЛТГҮЙ АЙМАГ - ДУНДГОВЬ"
ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Улс, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжил, ард иргэдийн оюун санаа, ахуй амьдралд архидан согтуурахаас үүдэлтэй сөрөг үр дагавар, хор хохирол асар их юм. Аймгийн хэмжээнд 2017 онд нийт 221 гэмт хэрэг бүртгэгдсэн ба үүний 29,8 хувийг согтуугаар үйлдсэн гэмт хэрэг эзэлж, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчил эрчимтэй буурахгүй байна.

"Архидалтгүй аймаг - Дундговь" дэд хөтөлбөр нь Монгол Улсын Үндсэн хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, аймгийн Засаг даргын 2018-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссаны дагуу ард иргэдээ архидалтгүй эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг нэмэгдүүлж, архидан согтуурахтай тэмцэх, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, олон нийт, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

Аймгийн хэмжээнд иргэдийн сайн дурын үүсгэл санаачилга, орон нутгийн удирдлагуудын идэвхтэй дэмжлэг, оролцоогоор зарим сумдад архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр тодорхой үйл ажиллагаа өрнөж, "Монголын эрэгтэйчүүдийн нийгэмлэг" ТББ, "Тамхи, архины шалтгаант эмгэг судлалын төв"-тэй хамтран архинаас татгалзах чин хүсэл, эрмэлзэлтэй залуучуудаа архины хор хөнөөл, аюул, гамшигийн талаар соён гэгээрүүлэх сургалтанд хамруулах, архидан согтуурахаас татгалзсан иргэд, залуучууддаа зохих дэмжлэг үзүүлэх зэргээр тэдний оюун санаа, ухамсарт нөлөөлсөн ажил, арга хэмжээний үр дүн гарч байсан. Аймгийн төвд Монголын "АА" нийгэмлэгийн салбарыг байгуулахад нь байраар хангах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж хамтран ажилласнаар эдүгээ 5 дахь жилтэйгээ золгож байгаа билээ. Тус "АА" төвийн гишүүд иргэдэд архинаас татгалзсан туршлагаа хуваалцаж, архинаас татгалзахыг санал болгосон уулзалт,

ярилцлага иргэдийн талархалыг хүлээж, тэдний оюун санаа, сэтгэлзүйд нөлөөлж дэмжлэг авахаар байна.

Эдгээр сайн жишээ, арга туршлагыг дэлгэрүүлж, архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэхэд иргэд, олон нийт, албан тушаалтны оролцоо, хариуцлага, хамтын ажиллагааг нэмэгдүүлж, архидан согтуурахтай тэмцэх, архидалтгүй орчин бүрдүүлэхэд иргэд, иргэний нийгмийн байгууллагын идэвхтэй оролцоо, хүчийг нэгтгэн архины хамаарлаас татгалзах чин эрмэлзэлтэй залуучуудаа дэмжих, тэднийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, удирдлага арга зүйг шинэчилж "Архидалтгүй аймаг - Дундговь" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь хэрэгцээ, шаардлага байна.

Хоёр.Хөтөлбөрийн зорилго

Аймгийн хэмжээнд архи, согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, хорт зуршлаас сэргийлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэхэд төрийн болон ТББ, иргэд, аж ахуй нэгжийг идэвхтэй татан оролцуулж, дэмжлэг үзүүлж, зохион байгуулалтаар хангаж архидалтаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх сөрөг үр дагаврыг бууруулахад хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав.Хөтөлбөрийн зорилт

3.1. Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, эмчлэн сэргийлэх, нийгэм сэтгэл зүйн тусламж үйлчилгээг өргөжүүлэхэд чиглэсэн аливаа үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, зохион байгуулалт, удирдлагаар хангах, бүх нийтийг татан оролцуулах замаар архидалтын эсрэг нэгдэж архи согтууруулах ундааны хэрэглээг бууруулах,

3.2. Хүн амын дунд архи согтууруулах ундааны хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг тогтмолжуулж, эрүүл зан үйлийг дэмжсэн ухамсар, сэтгэлзүйг төлөвшүүлэх,

3.3. Хууль тогтоомжийн дагуу архи, согтуурах ундааны хэрэглээ, худалдаа үйлчилгээнд байнгын хяналт тавьж, сахилга, хариуцлагыг нэмэгдүүлж, архидан согтуурахаас урьдчилан сэргийлж, архинаас үүдэлтэй гэмт хэрэг зөрчлийг бууруулах,

Дөрөв.Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Хөтөлбөрийн 3.1 дэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.1.1. Архидалттай тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажил, арга хэмжээг тусгайлан шалгуур үзүүлэлт болгон сум, баг, байгууллагын ажил дүгнэх үзүүлэлтэнд оруулж дүгнэх, дэмжих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

4.1.2. Аймаг, сум, баг, байгууллагын хэмжээнд архи, согтууруулах ундааны хэрэглээг багасгах, архидалттай тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хэлэлцүүлэг, ярилцлагыг мэргэжлийн байгууллага, иргэдийг оролцуулан зохион байгуулж, бодитой санал санаачилгыг дэмжиж, хэрэгжүүлнэ.

4.1.3. Архидалтгүй орчин бүрдүүлэхэд чиглэсэн бодитой үйл ажиллагаа, санал санаачилга гаргасан ТББ, АА –ийн бүлэг, сайн дурын клуб, бүлэгт шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлж, архи, согтуурах ундаа хэрэглэхээс бүрэн татгалзаж бусдыг үлгэрлэн манлайлж байгаа иргэдийг ажлын байраар хангах, зээл олгох, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр дэмжиж идэвхжүүлнэ.

4.1.4. Хамт олноороо архи, согтууруулах ундаа хэрэглэдэггүй, архигүй орчин бүрдүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжийг алдаршуулахын зэрэгцээ тэдний туршлагыг нийтэд сурталчилж, дэлгэрүүлнэ.

4.1.5. Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон ТББ, аж ахуй нэгж байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, уялдаа холбоог бэхжүүлнэ.

4.1.6. "Архидан согтуурахтай тэмцэх сан" байгуулж, ашиглах журмыг хууль тогтоомжийн хүрээнд баталж, мөрдүүлнэ.

4.2. Хөтөлбөрийн 3.2 дах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ

4.2.1. Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр эрх зүйн сургалт, сэрэмжлүүлэг мэдээ, сайн туршлагыг хэвлэл мэдээлэл/TV, сонин бусад /-ийн хэрэгсэл, АС цогцолборын тодорхой хуваариар, сум, багуудын өдөрлөг зэрэг нэгдсэн арга хэмжээний үеэр тус тус сурталчилж, соён гэгээрүүлэх ажлыг нэмэгдүүлнэ.

4.2.2. Аймгийн хэмжээнд чин хүслээрээ архины хамаарлаас гаргахыг хүссэн иргэдэд эрүүл аж төрөх зан үйл, архидалтаас үүдэлтэй сөрөг үр дагавар, хор уршгийн талаар системтэй мэдлэг олгож, тэднийг өөрийн ухамсар, оюун санаагаараа хорт зуршлаас ангижрах нөхцлийг бүрдүүлнэ.

4.2.3. Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, татгалзах ухамсар, сэтгэлзүйг төлөвшүүлэхэд чиглэсэн "АА" бүлэг байгуулах сайн дурын үүсгэл санаачилгыг дэмжиж, хамтран ажиллана.

4.2.4. Аймгийн хэмжээнд архи хэтрүүлэн хэрэглэдэг иргэдийн судалгаа гаргах, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг төрийн болон ТББ мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

4.2.5. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Наркологийн өрөө, танхим байгуулж, мэргэжилтэн, хүний нөөцийг сургахын зэрэгцээ сумдын Эрүүл мэндийн төвүүдийг түшиглэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, архи хэтрүүлэн хэрэглэдэг зарим иргэдийг эмчлэн эрүүлжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

4.2.6. Архи, согтууруулах ундааны хор хөнөөл, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг сурталчилах "Нээлттэй мэдээллийн өдөрлөг"-ийг нийтийг хамруулан сум, багийн хэмжээнд зохион байгуулна.

4.2.7. Өсвөр үе, хүүхэд, залуучуудын дунд архи, согтууруулах ундааны хор хөнөөл, түүнээс сэргийлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг төрөл бүрийн хэлбэрээр бүх шатанд системтэй зохион байгуулна.

4.3. Хөтөлбөрийн 3.3 дах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ

4.3.1. Архи согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг хүн амын тоо, үйлчилгээний хүрээ, эрүүл мэнд, соёлын байгууллага, сурагчдын хичээлийн болон дотуур байр, байршил зэргийг харгалзан цэгцэлж, хяналт тавих хэрэгжүүлэхдээ холбогдох мэргэжлийн байгууллагууд, иргэд, ИНБ-ын оролцоог бүрэн хангана.

4.3.2. Иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, тэдний санал хүсэлтэд тулгуурлан аймгийн хэмжээнд сар бүрийн тодорхой өдрүүдэд Архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглож, тухайн өдрүүдэд архины хор хөнөөлийг сурталчилдаг байхаар шийдвэр гарган мөрдөж, хэрэгжилтэнд хяналт тавихад холбогдох мэргэжлийн байгууллага, иргэд, ИНБ-ын оролцоог хангана.

4.3.3 Олон нийтийн газар, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын албан байр, нийтийн эзэмшлийн болон гэр хорооллын гудамж талбай, орон сууцны орц, овоо толгод, хөшөө цогцолбор, цэцэрлэгт хүрээлэн зэрэг зориулалтын бус газар архи, согтууруулахтай тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд олон нийт, цагдаагийн хамтын ажиллагааг нэмэгдүүлж Олон нийтийн эргүүл, жижүүрийг

төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулж, гудамж, талбайн гэрэлтүүлэг, камерын хяналтын тогтолцоог нэвтрүүлж үр дүнд хүрнэ.

4.3.4. Ажлын цагаар болон ажлын байранд архидан согтуурсан ажилтан, төрийн албан хаагчийг ажлаас шууд халах талаар аж ахуй нэгж, албан байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээнд тусган, дотоод хяналтыг нэмэгдүүлж, ажилтан, албан хаагчдын архидан согтуурсан талаарх мэдээллийг иргэдээс шуурхай хүлээн авч, зохих хариуцлага тооцож архидан согтуурахтай тэмцэнэ.

4.3.5. Нутаг дэвсгэрийн хэмжээнд архи, согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах, түүгээр үйлчлэхтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтийн хяналтыг нэмэгдүүлэх ажлыг хууль хяналтын болон мэргэжлийн байгууллагуудаас эрчимжүүлж, зөрчсөн тохиолдол бүрт хариуцлага тооцож, архи согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгоно.

4.3.6. Хууль бусаар зөвшөөрөлгүйгээр гар дээрээс архи согтууруулах ундаа худалдах, стандартын бус архи, согтууруулах ундаа худалдах зөрчилтэй тууштай тэмцэж, урьдчилан сэргийлнэ.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, хугацаа

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, үр дүнг тооцох эрчимжүүлэх ажлыг аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ, ХОХБТХ, НБХ болон бусад төрийн байгууллагууд хариуцан гүйцэтгэж, мэргэжлийн үйл ажиллагааг аймгийн Засаг даргын харьяа агентлаг Цагдаагийн газар, МХГ, Стандарт хэмжилзүйн хэлтэс хэрэгжүүлэх бөгөөд хөтөлбөрт хамрагдсан төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгж харилцан үүрэг хүлээж, хамтран ажиллана.

5.2. Сумдад хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг сумдын Засаг дарга нар болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хариуцан иргэд олон нийтийг татан оролцуулж идэвхжүүлж, эрчимжүүлнэ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бусад байгууллагуудаас шаардлагатай дэмжлэгийг шуурхай авч ажиллана.

5.3. Хөтөлбөрийг 2018-2020 онд хэрэгжүүлэх бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг хагас жил тутам тооцож, үйл ажиллагаагаа жил жилээр төлөвлөнө.

Зургаа. Хөтөлбөрийн үр дүн буюу шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарсан байна.

6.1. Аймгийн хэмжээнд архины борлуулалт буурч, архи, согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй эрхлэгчдээс хамааралтай ноцтой зөрчил, дутагдалгүй болсон байх,

6.2. Архигүй, эрүүл зан үйлийг дэмжсэн, дэлгэрүүлсэн сайн туршлага Улс, аймгийн хэмжээнд нэвтэрч, олон нийтэд танигдсан байх,

6.3. Согтуугаар үйлдэгдсэн болон гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэргийн тоо буурсан байх,

6.4. Согтуугаар захиргааны зөрчил гаргасан болон эрүүлжүүлэгдсэн хүний тоо буурсан байх,

6.5. Архи хэтрүүлэн хэрэглэдэг иргэдийн тоо буурсан байх,

Долоо.Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

7.1. Жил бүрийн Улсын болон орон нутгийн төсөв/орон нутгийн хөгжлийн сан/-ийн хөрөнгө,

7.2. Олон Улсын байгууллагын төсөл, хөтөлбөр, зээл тусламж, хандивын хөрөнгө,

7.3. Аж ахуйн нэгж, байгууллага, ард иргэдийн хандивын хөрөнгө,

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС

БАТЛАВ

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

2018 оны 05 сарын 28 ны өдөр

"АРХИДАЛТГҮЙ АЙМАГ - ДУНДГОВЬ" ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ
2018 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах байгууллага, албан тушаалтан
1.	"Архидалтгүй аймаг - Дундговь" дэд хөтөлбөрийг иргэд, олон нийтэд сурталчлах удирдамж, чиглэл боловсруулж сум, байгууллагад хүргүүлж хэрэгжүүлнэ.	-Дэд хөтөлбөрийг сурталчлах удирдамж баталж сумдад хүргэсэн байх,	6-р сард	ХЭЗХ ЦГ ЭМГ
2.	Архи согтууруулах ундааны хэрэглээг багасгах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажил, арга хэмжээг сум, байгууллагын ажил дүгнэх үзүүлэлтэнд оруулж дүгнэх, дэмжих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	-Сум, байгууллагын ажил дүгнэх үзүүлэлтэнд тодорхой үзүүлэлтүүд туссан байх,	6-р сард	ТЗУХ
3.	Архи, согтууруулах ундааны хор хөнөөл, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг сурталчилах "Нээлттэй мэдээллийн өдөрлөг"-ийг нийтийг хамруулан сум, багийн хэмжээнд зохион байгуулна.	"Нээлттэй мэдээллийн өдөрлөг"-ийг зохион байгуулах удирдамж, чиглэл батлагдсан байх,	9-р сард	ХЭЗХ, ЦГ, ЭМГ Сумдын ГХУССЗ, Засаг дарга нар
4.	Аймгийн хэмжээнд архины хэрэглээ, хор хөнөөлийн талаарх судалгааг шинэчлэн гаргаж, Нэгдсэн эмнэлэгийн наркологийн тасагт эмчлэн эрүүлжүүлэх, сургалт мэдээллээр хангах ажлыг үе шаттай зохион байгуулна.	-Судалгаа гарсан байх, -Сургалт, сурталчилгаа, эмчилгээг төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулсан байх,	5-р сараас	ЦГ, ЭМГ Сумдын ГХУССЗ, Засаг дарга нар
5.	Мэргэжлийн ТББ-тай хамтран иргэд залуучуудыг оролцуулан "Томоогүй явж боллоо ээжээ" чуулган зохион байгуулж, архины хор хөнөөл, сөрөг үр дагаварын талаар лекц мэдээллээр хангах, удирдамж чиглэл зохион байгуулна.	"Томоогүй явж боллоо ээжээ" чуулганы хөтөлбөр батлагдсан байх, -Иргэд, олон нийтийг өргөн оролцуулсан байх,	6-р сард	ХЭЗХ, ЦГ, Сайнцагаан сумын ГХУССЗ, сумдын Засаг дарга нар
6.	Аймгийн хэмжээнд "Архигүй өдөр" тогтоосон аймгийн ИТХ-ын шийдвэр гарган сурталчилж, хэрэгжүүлнэ.	-Шийдвэр батлагдаж, сумдад хүргүүлсэн байх,	6-р сараас	АИТХ-ын ажлын алба, ХЭЗХ

7.	Архидан согтуурахтай тэмцэх, гэмт хэрэгтэй тэмцэх талаар багийн ИНХ-ын дарга, багийн Засаг дарга нарыг үүрэг, оролцоог сайжруулах талаар нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж, ажил дүгнэх үзүүлэлтэд тусгайлан оруулж үр дүнд хүрнэ.	-Ажлын үзүүлэлтэд тусгай үзүүлэлтүүдийг тусгаж дүгнэж хэвшсэн байх,	Улирал бүр	ТЗУХ, ХЭЗХ Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нар
8.	"Архигүй орчин" бүрдүүлэхэд чиглэсэн бодитой үйл ажиллагаа, санал санаачилга гаргасан ТББ, АА –ийн бүлэг, сайн дурын клуб, бүлэгт зохион байгуулалтын болон бусад дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.	-Сум, баг бүрт тодорхой санал, санаачлага өрнөсөн байх,	Тухай бүр	ХЭЗХ, ЦГ, ЭМГ, Сумдын ГХУССЗ, ЗДТГ
9.	"Архи шинэ үеийн сонголт биш" сэдвийн дор иргэд залуучуудыг оролцуулан сум, багийн хэмжээнд "Дэвжээ" арга хэмжээг зохион байгуулж, иргэдийг хамруулна.	-Сум бүрд "Дэвжээ" арга хэмжээ зохион байгуулагдсан байх,	11 дүгээр сард	БСУГ, ГБХЗХГ, Сумдын ЗДТГ, ЕБС
10.	Өсвөр үе, хүүхэд багачуудын дунд архи, согтууруулах ундааны хор хөнөөл, түүнээс сэргийлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулахын зэрэгцээ "Архигүй аз жаргалтай гэр бүл" сэдэвт Эссэ бичлэг, "Архидалт ба хүчирхийлэл" сэдэвт гар зургийн уралдааныг аймгийн хэмжээнд зохион байгуулж, сурталчилна.	-Аймгийн хэмжээнд ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулсан Эссэ бичлэг, гар зургийн уралдаанд шалгарсан бүтээлийг нийтийн хүртээл болгосон байх,	9, 10 дугаар сард	БСУГ, ГБХЗХГ, ЦГ, Сумдын ЗДТГ, ЕБС
11.	Архи, согтууруулах худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах журмыг шинэчилж, цэгийн тоог аймгийн хэмжээнд хүн амын тоонд харьцуулан тогтоосон шийдвэр гаргаж мөрдүүлнэ.	-Шийдвэрүүдийг баталж, сумдад хүргэсэн байх,	Жилдээ	ХОХБТХ ХЭЗХ ЦГ
12.	Архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг газруудад холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэнд тавих хяналтыг тогтмолжуулж, холбогдох мэргэжлийн байгууллага, албан тушаалтан, Иргэний нийгмийн байгууллага, иргэний төлөөлөл, орон нутгийн захиргааны байгууллагын төлөөллийг оролцуулсан ажлын хэсгийг ажиллуулна.	-Ажлын хэсэг байгуулагдсан байх, -Шинэчлэн батлагдсан журмын хэрэгжилтийг хангасан байх,	10, 11 дүгээр сард	ХЭЗХ, ЦГ, МХГ, СХЗХ Сумдын ЗДТГ

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС